

## **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2008 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2008.08.18

Улаанбаатар хот

### **НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Тайлант улиралд Дархан өсөх ХХК-нд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны тогтоолоор олгож, Их түншлэл, Инфраструкчер зэрэг 2 ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны тогтоолоор хүчингүй болгосноор нийт 130 ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдлаа.

Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээг ББСБ-уудын эрхэлж буйгаар нь ангилахад зээлийн үйл ажиллагаа 128, факторингийн үйлчилгээ 8, санхүүгийн түрээсийн үйлчилгээ 6, төлбөрийн баталгаа гаргах 5, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах 1, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 9, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа 54, итгэлцлийн үйлчилгээ 14, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх 2, хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ 6 ББСБ эрхэлж байна.

Улаанбаатар хот болон орон нутаг дахь ББСБ-ын нийт салбар, нэгжийн тоо 45, нийт хувь нийлүүлэгчдийн тоо 415, нийт ажиллагсдын тоо 654 гаруйд хүрсэн ба давхардсан тоогоор 52.7 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээг үзүүлжээ.

Орон нутагт 22 ББСБ ХХК үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-уудын 16.9 хувийг, тэдгээрийн нийт актив 2,093.5 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын активын 2.9 хувийг, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 1,578.8 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 3.9 хувийг тус тус эзэлж байгаа ба байршлын хувьд авч үзвэл Дорнод, Дархан-Уул аймагт тус бүр 4, Орхон аймагт 3, Хөвсгөл, Төв зэрэг аймгуудад тус бүр 2, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Архангай, Баянхонгор, Хэнтий, Дорноговь зэрэг аймгуудад тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 10 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.7 хувийг, тэдгээрийн нийт актив 11,083.5 сая төгрөгт хүрсэн нь ББСБ-ын нийт активын 15.4 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив 4,064.7 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 10.1 хувийг тус тус эзэлж байна.

Судалгаанаас үзэхэд ББСБ-уудын олгож буй зээлийн хүүгийн түвшин дундажаар 3.0-4.5 хувь, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүгийн түвшин дундажаар 0.5-2.0 хувь байна.

ББСБ-уудын нийт актив **71,966.5** сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын **/банкны салбарын нийт актив 3,760,326.6 сая төгрөг/** 1.9 хувьтай тэнцэж байгаа ба активын өгөөж 5.6 /ROA/ хувь байна.

Өөрийн хөрөнгө **48,951.0** сая төгрөгт хүрсэн нь нийт банкны салбарын эзэмшигчдийн өмчийн **/эзэмшигчийн өмч 412,097.3 сая төгрөг/** 11.9 хувьтай тэнцэж байгаа ба өөрийн хөрөнгийн өгөөж 7.8 /ROE/ хувь байна.

ББСБ-уудын нийт олгосон зээл **40,410.1** сая төгрөг байгаа банкны салбарын нийт олгосон зээлийн **/2,579,961.9 сая төгрөг/** 1.6 хувьтай тэнцэж байна.

## **ХОЁР. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 1,717.3 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад */өмнөх оны мөн үеийн цэвэр ашиг 1,052.2 сая төгрөг/* 66.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь ББСБ-уудын үйл ажиллагааны цар хүрээ өсч, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр нэмэгдэн, санхүүгийн зуучлалын хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор нийт орлого өссөн, өөрөөр хэлбэл, нийт орлогын өсөлтийн хурдац нийт зардлын өсөлтийн хурдацаас их байгаатай холбоотой байна.

Нийт орлогын 62.7 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байгаа нь ББСБ-уудын хувьд зээлийн хүүгийн орлого нь нийт орлогын гол эх үүсвэр болсоор байгааг харуулж байна.

Харин нийт зардал өмнөх оны мөн үеэс */өмнөх оны мөн үед нийт зардал 4,795.9 сая төгрөг/* зардал зүйл тус бүрээр өссөнөөр, нийт зардал 45.0 хувь буюу 2,160.0 сая төгрөгөөр өсч 6,956.0 сая төгрөгт хүрсэн ба дараах бүтэцтэй байна. Үүнд:

Нийт зардлын 30.0 хувийг ханшийн тэгшитгэл, арилжааны, 20.3 хувийг боловсон хүчний холбогдолтой, 9.4 хувийг бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хүүгийн, 6.5 хувийг эрсдлийн зардал тус тус эзэлж байна.

Нийт зардлын өсөлтийн шалтгаан нь ББСБ-уудад итгэлцлийн үйлчилгээгээр санхүүгийн эх үүсвэр бусдаас татан төвлөрүүлж байгаа, банк, санхүүгийн байгууллагаас зээл авах хандлага нэмэгдсэн, дамжуулан зээлдүүлэх төсөлд хамрагдах ББСБ-уудын тоо өссөн зэрэг обьектив хүчин зүйлээс шалтгаалж хүүгийн зардал өссөн, үйлчилгээний цар хүрээ өргөжсөн болон ББСБ-уудын механик тоон өсөлттэй холбоотойгоор үйл ажиллагааны болон боловсон хүчинтэй холбоотой зардал нэмэгдсэн зэрэгтэй холбоотой.

Тайлант хугацаанд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 106 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 81.5 хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн ашиг 21.1 мянган төгрөгөөс 222.5 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Харин 19 ББСБ буюу нийт ББСБ-уудын 14.6 хувь нь 100.0 мянган төгрөгөөс 288.3 сая төгрөг хүртэл алдагдалтай ажиллажээ.

## **ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

### **3.1 Активын өөрчлөлтийн талаар**

Нийт эх үүсвэр нэмэгдсэнээр нийт актив өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт активын бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого авчирдаг активын өсөлтийн хурдац нь нийт активын өсөлтийн хурдацаас их байгаагаас нийт активт эзлэх хувийн жин нь 43.3-54.2 хувь, нийт авлага өмнөх оны мөн үеэс 16.7 дахин нэмэгдсэнээр нийт активт эзлэх хувь 0.2-3.7 хувь болж өссөн байна.

Эргэлтийн бус хөрөнгийн бүлгээс өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө зэргийг хасч тооцохоор ББСБ-ын нягтлан бодох бүртгэлийн журам шинэчлэгдсэнээр эргэлтийн бус хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин 17.3-6.2 хувь, харин Инфрастракчер ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой хобоотойгоор богино хугацаат хөрөнгө оруулалтын нийт активт эзлэх хувийн жин 6.0-0.7 хувь болж тус тус буурсан.

Тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

		Тайлант үе		Өмнөх оны мөн үе		Өөрчлөлт	
ХӨРӨНГӨ		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>A</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>67,499,607.8</b>	<b>93.8%</b>	<b>58,186,284.6</b>	<b>82.7%</b>	<b>9,313,323.20</b>	<b>11.1%</b>
1	Мөнгөн хөрөнгө	19,281,042.1	26.8%	17,820,937.0	25.3 %	1,460,105.10	1.5%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	489,923.1	0.7%	4,205,500.1	6.0 %	-3,715,577.00	-5.3%
3	Зээл /цэврээр/	39,026,593.1	54.2%	30,472,749.8	43.3 %	8,553,843.30	10.9%
	<i>(Зээлийн эрсдлийн сан)</i>	<i>1,383,540.3</i>	<i>1.9%</i>	<i>933,458.4</i>	<i>1.3%</i>	<i>450,081.90</i>	<i>0.6%</i>
4	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	180,996.6	0.3%	292,952.3	0.4%	-111,955.70	-0.1%
	<i>Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө</i>	<i>185,233.1</i>	<i>0.3%</i>	<i>399,121.6</i>	<i>0.6%</i>	<i>-213,888.50</i>	<i>-0.3%</i>
	<i>(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдлийн сан)</i>	<i>87,046.7</i>	<i>0.1%</i>	<i>106,169.3</i>	<i>0.2%</i>	<i>-19,122.60</i>	<i>-0.1%</i>
	<i>Өмчлөх бусад хөрөнгө</i>	<i>82,810.2</i>	<i>0.1%</i>	<i>-</i>	<i>-</i>		
5	Бусад хөрөнгө	8,518,753.5	11.8%	3,727,109.1	5.3 %	4,791,644.40	6.5%
	<i>Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага</i>	<i>1,072,534.7</i>	<i>1.5%</i>	<i>909,816.2</i>	<i>1.3 %</i>	<i>162,718.50</i>	<i>0.2%</i>
6	Нийт авлага	2,654,505.2	3.7%	159,116.4	0.2 %	2,495,388.80	3.5%
	<i>(Авлагын эрсдлийн сан)</i>	<i>3,969.8</i>	<i>0.0%</i>	<i>312,315.7</i>	<i>0.4%</i>	<i>-308,345.90</i>	<i>-0.4%</i>
7	Бусад актив	4,795,683.5	6.7%	3,727,109.1	5.3%	1,068,574.40	1.4%
<b>B</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>4,466,897.9</b>	<b>6.2%</b>	<b>12,162,987.1</b>	<b>17.3 %</b>	<b>-7,696,089.20</b>	<b>-11.1%</b>
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,466,897.9	6.2%	11,870,034.9	16.9 %	-7,403,137.00	-10.7%
	<i>(Хуримтлагдсан элэгдэл)</i>	<i>1,002,551.0</i>	<i>1.4%</i>	<i>292,952.3</i>	<i>0.4 %</i>	<i>709,598.70</i>	<i>1.0%</i>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>71,966,505.7</b>	<b>100.0%</b>	<b>70,349,271.7</b>	<b>100.0%</b>	<b>1,617,234.00</b>	<b>100.0%</b>

### 3.2 Активын багцын чанар

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 9,003.9 сая төгрөгөөр өсч 40,410.1 сая төгрөгт хүрсэнээр нийт активын 54.2 хувийг эзэлж байгаа ба бүтцийг нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлтүүд	Тайлант үе		Өмнөх оны мөн үе		Өөрчлөлт
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн
1	Хэвийн	37,489,049.5	91.8 %	28,843,046.3	92.8 %	8,646,003.2
2	Хугацаа хэтэрсэн	1,228,410.9	3.2 %	1,018,682.0	3.0 %	209,728.9
3	Чанаргүй. Үүнээс:	1,692,673.0	4.9 %	1,544,479.9	4.2 %	148,193.1
	<i>а/ Хэвийн бус</i>	<i>433,689.3</i>	<i>1.4 %</i>	<i>437,808.0</i>	<i>1.1 %</i>	<i>-4,118.7</i>
	<i>б/ Эргэлзээтэй</i>	<i>367,893.1</i>	<i>1.8 %</i>	<i>566,507.9</i>	<i>0.9 %</i>	<i>-198,614.8</i>
	<i>в/ Муу</i>	<i>891,090.6</i>	<i>1.7 %</i>	<i>540,163.99</i>	<i>2.2 %</i>	<i>350,926.6</i>
	<i>Эрсдэлийн сан</i>	<i>1,383,540.3</i>	<i>3.0 %</i>	<i>933,458.4</i>	<i>3.4 %</i>	<i>450,081.9</i>
	<b>НИЙТ</b>	<b>40,410,133.4</b>	<b>100 %</b>	<b>31,406,208.2</b>	<b>100 %</b>	<b>9,003,925.2</b>

### ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЛААР

#### 4.1 Нийт эх үүсвэрийн өөрчлөлтийн талаар

Нийт эх үүсвэрийн бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон. Тухайлбал, төслийн зээлийн санхүүжилт 2.3 дахин, хуримтлуулж тооцсон хүүгийн орлого 7.8 дахин өссөн, харин банкнаас авсан зээлийн хэмжээ 4,893.2 сая төгрөгөөр буурсантай холбоотойгоор нийт өр төлбөрийн дүнд огцом өөрчлөлт гараагүй байна.

Харин эзэмшигчдийн өмчийн дүнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хуримтлагдсан ашгийн өсөлтөөс шалтгаалж 2.1 хувиар өсч, нийт эх үүсвэрийн 68.0 хувийг эзэлж байгаа ба энэ нь бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх явц нь зохистой түвшинд байгааг харуулж байна.

Тайлант улирлын нийт эх үүсвэрийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		Тайланг үе		Өмнөх оны мөн үе		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>A</b>	<b>Өр төлбөр</b>	<b>18,971,106.4</b>	<b>26.4%</b>	<b>19,061,817.1</b>	<b>27.1%</b>	<b>-90,710.7</b>	<b>-0.7%</b>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,752,254.7	3.8%	2,755,066.8	3.9%	-2,812.1	-0.1%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	8,035,162.0	11.2%	12,928,314.5	18.4%	-4,893,152.5	-7.2%
3	Бусад эх үүсвэр	1,706,260.0	2.4%	522,767.5	0.7%	1,183,492.5	1.7%
5	Төслийн зээлийн санхүүжилт	6,477,429.7	9.0%	2,855,668.4	4.1%	3,621,761.3	4.9%
	<b>Бусад өр төлбөр</b>	<b>4,044,367.7</b>	<b>5.6%</b>	<b>3,310,366.7</b>	<b>4.7%</b>	<b>734,001.0</b>	<b>0.9%</b>
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,072,534.7	1.5%	138,244.3	0.2%	934,290.4	1.3%
7	Бусад пассив	4,795,683.5	6.7%	3,172,122.3	4.5%	1,623,561.2	2.2%
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>23,015,474.1</b>	<b>32.0%</b>	<b>22,372,183.7</b>	<b>31.8%</b>	<b>643,290.4</b>	<b>0.2%</b>
<b>B</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>48,951,031.6</b>	<b>68.0%</b>	<b>47,977,087.9</b>	<b>68.2%</b>	<b>973,943.7</b>	<b>-0.2%</b>
	Ердийн хувьцаа	42,689,707.4	59.3%	42,712,841.0	60.7%	-23,133.6	-1.4%
	Давуу эрхтэй хувьцаа	44,850.5	0.1%	163,020.1	0.2%	-118,169.6	-0.1%
10	Бусад өмч	710,728.0	1.0%	381,667.7	0.5%	329,060.3	0.5%
11	Сангууд	1,123,257.7	1.6%	1,077,856.0	1.5%	45,401.7	0.1%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	3,936,638.3	5.5%	2,437,356.4	3.5%	1,499,281.9	2.0%
	Тухайн үеийн ашиг/алдагдал	1,717,316.9	2.4%	1,052,151.0	1.5%	665,165.9	0.9%
	Хуримтлагдсан ашиг/алдагдал	2,219,321.3	3.1%	1,385,205.4	2.0%	834,115.9	1.1%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	445,849.6	0.6%	1,204,346.8	1.7%	-758,497.2	-1.1%
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>71,966,505.7</b>	<b>100.0%</b>	<b>70,349,271.7</b>	<b>100.0%</b>	<b>1,617,234.00</b>	<b>100.0%</b>

## БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР